



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 36

Сүхбаатар сум

Ёс зүйн хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 288 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Боловсрол, соёл, урлагийн газрын “Ёс зүйн хороо”-г дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Ёс зүйн хорооны дарга- Ц.Золжаргал

/Салбарын хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн/

Гишүүдэд: П.Мягмарсүрэн /Бага боловсролын мэргэжилтэн/

Т.Сундуй /Физик, газарзүйн боловсролын мэргэжилтэн/

Хоёр. Байгууллагын хэмжээнд төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж, гомдол мэдээллийг журмын дагуу тухай бүр шийдвэрлэн, тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ажиллахыг Ёс зүйн хорооны дарга, гишүүдэд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ч.ЖАРГАЛСАЙХАН

